

ЦАХИМ ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛӨӨС ҮҮДЭЖ БУЙ ХӨРӨНГИЙН ТУХАЙ

ABOUT ASSETS ARISING FROM THE DEVELOPMENT OF DIGITAL TECHNOLOGY

Б.Лодойсамбуу

Шихихутуг Их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш

Товч агуулга. Сүүлийн жилүүдэд цахим технологи, мэдээллийн салбар үсрэнгүй хөгжихийн хэрээр уламжлалт хөрөнгийн ойлголт хийгээд түүний харилцаа харьцангуй хоцрогдох байдал бий болсоор байна. Хүмүүс бэлэн мөнгөний хэрэглээгээ багасгаж өдөр тутмын худалдан авах үйл ажиллагаандаа өөрийн харилцах банкны картаар аль эсвэл цахим банкаар дамжуулан төлбөр тооцоо хийх бүр цаашлаад зарим тохиолдолд өөр бусад хэлбэрийн дижитал хөрөнгүүдээр худалдан авалт хийх боломжтой болжээ. Дижитал хөрөнгө гэх ойлголт нь технологийн тусламжтайгаар дижитал орчинд худалдан авч, хадгалж, шилжүүлж, арилжаалж болох мөнгө түүгээр орлогдох үнэ цэнийг агуулж буй хэрэглээний ойлголт юм. Цахим технологийн хөгжлийг дагаж сүүлийн жилүүдэд криптовалюта буюу виртуал хөрөнгөтэй холбоотой блокчейн технологид суурилсан coin¹, token², nft³ зэрэг санхүүгийн бүтээгдэхүүнүүд болон санхүүгийн технологийн үйл ажиллагаатай холбоотой дижитал орчинд үнэ цэнэ бүхий хөрөнгүүд шинээр бий болсоор байна.

Abstract: In recent years, with the rapid development of electronic technology and the information industry, the traditional concept of capital and its relationship have become relatively outdated. People have reduced the use of cash and made daily purchases using their bank cards or electronic banking, and in some cases, they have been able to make purchases with other forms of digital assets. The concept of digital assets is a consumer concept that can be purchased, stored, transferred, and traded in a digital environment with the help of technology and has the value of money. Following the development of electronic technology, in recent years, financial products such as coins, tokens, and NFTs based on blockchain technology related to cryptocurrencies or virtual assets, and new assets with value in the digital environment related to financial technology activities have emerged.

Түлхүүр үг: Дижитал хөрөнгө, цахим хөрөнгө, криптовалюта, цахим технологи

Keywords: Digital assets, electronic assets, cryptocurrency, electronic technology

Нэг. Цахим технологийн хөгжлөөс үүсэж буй хөрөнгө

Хүн төрөлхтний суурин соёл иргэншилд орсон үеэс хойших нийгмийн хөгжлийн явцад олж авсан хамгийн том ололт бол яах аргагүй интернэт буюу цахим мэдээллийн орчин юм. Уг талбарыг хүмүүс өөр өөрийн ажил мэргэжлийн хэрэгцээнд тохируулан янз бүрийн байдлаар ашиглаж мэдээлэл олж авах, солилцох, бусдад түгээхэд ашиглаж өөрийн цаг хугацааг хэмнэх бусад санхүүгийн хувьд үр ашиггүй, алдагдал хүлээхгүйгээр үйл

¹ Койн гэж өөрийн гэсэн блокчейн сүлжээнд суурилсан блок схемүүдээр өөрийн мэдээллийг хадгалдаг, сүүлийн үеийн санхүүгийн бүтээгдхүүн юм.

² Токен гэж аливаа блокчейн технологид суурилж өөрийн мэдээллийг агуулж цахим хөрөнгөд хамаарах хэрэглээний объект юм.


³ NFT- Non Fungible token гэдэг нь блокчейн дээр суурилсан дахин орлогдошгүй үнэ цэнийг агуулж буй бүтээгдхүүн юм. Сүүлийн жилүүдэд хүмүүс өөрийн бүтээлийг NFT болгон виртуал орчинд худалдах болсон ба Их, дээд сургуулиуд оюутны мэдээлэл болон дифломыг NFT болгох болсон.

ажиллагаагаа хөнгөвчлөх зэргээр ашиглаж хэдийнээ дэлхий нийтийн хэрэглээний салшгүй чухал хэрэглүүр болжээ.

Үүний зэрэгцээгээр цахим технологийн бүтээгдэхүүнүүд өөрийн гэсэн үнэ цэнийг тодорхой хэмжээнд агуулж хүмүүсийн дунд идэвхтэй хэрэглээнд орж, мөнгө болон түүгээр орлогдох шинжтэйгээр ашиглагдсаар байгаа. Жишээлбэл, харилцаа холбооны салбарт гар утасны нэгж, санхүүгийн салбарт банкны харилцах дансанд буй мөнгө, хувьцаа, виртуал хөрөнгүүд зэрэг багтана.

Дижитал⁴ хөрөнгийн хамгийн анхаарал татсан сэдэв нь яах аргагүй криптовалют /cryptocurrency/ юм. Анхны криптовалют нь 2008 онд Биткойн /Bitcoin /Сатоши Накамото гэж нэрлэсэн нэгэн бүтээсэн гэдэг хэдий ч одоог хүртэл энэ хүн нь яг хэн болох өөрийгөө илчлээгүй байгаа нь анхаарал татсаар. Биткойн нь дэлхий дээр нийт 21 сая ширхэг байх боломжтой байхаар блокчэйн технологид кодлогдсон бөгөөд одоог хүртэл бүх биткойн олборлогдоогүй хүмүүс олборлосоор байгаа юм. Криптовальютын гол зорилго нь хүмүүсийн төлбөр тооцооны хэрэгслийн хараат бус байдлыг халах зорилготой буюу аливаа засгийн газраас хамааралтай бус байдлаар хүмүүс хоорондоо солилцох, арилжаалах боломжтой мөнгөн тэмдэгтийг бий болгох байсан гэж тайлбарладаг. Уг цахим хөрөнгийн давуу тал нь хүмүүс хоорондын шилжүүлэгт гүйлгээний шимтгэл байхгүй, мөн заавал гуравдагч этгээдийн оролцоотой шилжүүлэг хийгддэг байдлыг халах гэсэн гол үзэл баримтлалыг дэвшүүлдэг.

Биткойн нь анх гарахдаа нэгж ширхэг нь нэг долларын үнэлгээтэй байсан бол одоо зуу гаруй мянган долларын үнэлгээтэй цахим хөрөнгө болсон байна. Өөрөөр хэлбэл, зуу гаруй мянга дахин үнэ цэнэ өссөн байгаа юм.



⁴ Дижитал-Цахим гэж цахилгаан тооцоолон бодох техник, ийм төрлийн техник ашиглан үйл ажиллагаа явуулах; цахим карт., Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 2021он. 1137 тал.

Дээрх статистик, тоон үзүүлэлтээс үзэхэд биткойны ханш урт хугацаандаа маш өндөр өсөлттэй байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна.

Биткойн ийм өндөр өсөлттэй хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болсон цаашлаад үнэ цэн нь хаана оршиж байгаа зэрэг нь санхүүчид, хөрөнгө оруулагчдын дунд эргэлзээтэй байдал бий болгодог. Хувьцаа, үнэт цаас нь тухайн компанийн үйл ажиллагаа, хөрөнгөөр баталгаажсан байдлаараа өөрийн үнэ цэнийг агуулж байдаг шиг криптовалютын үнэ цэнэ нь яг юу болох, эдийн засгийн баталгаа байгаа эсэхийг тодорхойлох хэрэгцээ байсаар байгаа нь тухайн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөрөнгө гэж үзэх эсэх нь онолын хувьд маргаантай байдал бий болгоно.

Мөн сүүлийн жилүүдэд гар утас, компьютерын хэрэглээ ихсэхийн зэрэгцээ түүнийг дагасан хэрэглээний программ, аппликейшн маш ихээр бий болсоор байгааг бид бүхэн сайн мэднэ. Цахим тоглоом, и-спорт гэх ойлголтууд одоо бидний энэ үед танил сонсогдох хэмжээнд олон яригдах болсон байна. Залуучуудын дунд аль хэдийнээ хүчийг авсан байгаа энэ зүйл нь дан ганц тоглох гэхээс илүүтэйгээр түүний доторх тоглоомын эд хэрэгслүүд нь өөрийн гэсэн үнэ цэнийг бий болгосон байдаг төдийгүй маш өндөр үнэлгээтэй асар том эдийн засгийн эргэлт бий болгож байдаг. Скин /Skin⁵/ нь дийлэнхдээ заавал худалдаж авах нөхцөлтэй байдаг бөгөөд маш цөөхөн тохиолдолд үнэгүй буюу азтан болгох, хайрцаг нээлгүүлж өгөх зэргээр тухайн тоглоомыг тоглож буй тоглогчид өөрийн эзэмшилд авах боломжийг олгодог. Хамгийн анхаарал татаж байгаа зүйл нь тухайн тоглоомын тоглогч нь өөрийн тоглоомын аккаунт⁶-ыг мөнгөөр цэнэглэх, тухайн тоглоомд байх ямар нэгэн цахим зоосыг цэнэглэж тухайн зоосоороо тэр тоглоомд хамаарах үнэ цэнэ бүхий хөрөнгүүдийг худалдаж авах зэргээр өөрийн дураар захиран зарцуулах боломжтой. Тухайн аккаунт хэр зэрэг олон скинүүдтэй байна түүнийг дагаж тухайн тоглоомын хаягийн үнэ цэнэ тэр чинээгээрээ өндөр үнэлгээтэй болдог ба тоглоомын хүрээлэлдээ тоглогчид нэг нэгнийхээ аккаунтуудыг мөнгөөр худалдаж авах, зарах харилцаа үүсэх болсон.

Үүнээс харахад сүүлийн үеийн ихэнх тоглоомуудад ийм байдлаар тоглоомоос ашиг олох нийтлэг шинж ажиглагдаж байгаа бөгөөд зах зээлийн хувьд маш том хүрээнд хүрсэн байгаа юм. Энэ хүрээнд тухайн харилцаанаас үүсэх эрсдэл нь тухайлбал худалдаж авах, зарах харилцаанд ямар нэг асуудал үүссэн тохиолдолд аль нэг тал хохирвол тухайн үнэ цэнийг агуулаад байгаа аккаунтыг хүний эд хөрөнгө, баялаг гэж үзэх үү гэдэг асуулт гарч ирнэ. Нөгөөтээгүүр хувь тоглогч өөрийн аккаунтын доторх зоосыг өөрийн бодит мөнгөөр цэнэглэх явцад ямар нэг асуудал үүсэх, цаашлаад цэнэглэсэн байсан зоосоо бусдад алдсан тохиолдолд тухайн хөрөнгийг эргүүлэн шаардах эрх үүсэх үү зэрэг асуултууд гарч ирнэ.

Энэ мэтчилэн маш олон төрлийн шинэ хөрөнгийн ойлголтууд байгаа бөгөөд биднийг нэг өглөө сэрэхэд л нэг шинэ цахим хөрөнгийн зүйл бий болж байгаа нь тухайн хөрөнгийг хэрэглэж буй хүмүүсийн аюулгүй байдал тэр дундаа өмчийн холбогдолтой эрх зүйн хамгаалалт байгаа юу гэдэг эргэлзээтэй байдал байсаар..

Хоёр. Цахим хөрөнгийг эрх зүйгээр хамгаалахад тулгамдаж буй асуудал

Хүмүүс нийгмийн харилцаанд оролцохдоо янз бүрийн байдлаар төлбөрийн олон төрлийг цахим хэлбэрээр төлөх боломжийг олгож байгаа ч нөгөө талаар тухайн цахим хөрөнгө нь тухайн хүний өмч, хөрөнгө болохын хувьд эрх зүйн хамгаалалт тогтоох боломжтой эсэх нь эргэлзээтэй. Тухайлбал автобусанд суухдаа түүнд зориулсан төлбөрийн

⁵ Скин гэж тухайн тоглоомонд агуулагдаж буй хэрэглэл бөгөөд хэлбэр хэмжээ, өнгө үзэмж нь ямар байхаас хамааран өөрийн гэсэн үнэ цэнэ нь өөр өөр байдаг тухайн тоглоомын нэг бүтээгдхүүн юм.

⁶ Account гэж тус тоглоомыг тоглож буй тоглогчийн өөрийн бүртгэлтэй тоглож буй тухайлсан өөрт нь хамаарах тоглоомын хаягыг хэлнэ.

хэрэгслийг тодорхой нэгжээр цэнэглэж зорчих, цаашлаад санхүүгийн технологийн /финтек⁷/ байгууллагуудаас гарч буй санхүүгийн үйлчилгээнүүд нь өөрсдийн гэсэн нэгж хөрөнгийг тухайн үйлчилгээндээ санал болгодог ба тухайн нэгж дүн нь төгрөгтэй харилцах хамаарал бусад ижил төсөөтэй хөрөнгүүдээс ялгамжтай байх боломжтой байгаа нь анхаарал татаж байгаа юм.

Иргэний хуулийн 83.1-т “Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно” гэж хуульчилжээ. Дижитал хөрөнгүүд нь эдийн бус баялаг гэж тооцогдохын хүрээнд хуулиар хориглоогүй байх, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй байх гэсэн шалгуурыг хангах шаардлагатай байхаар хуульд ерөнхий байдлаар тусгасан байна.

Үүнээс үзвэл хэрэглээнд нэвтэрсэн цахим хөрөнгүүдийг эл шинжийг хангаж байгаа байгаа эсэхээр баялаг мөн эсэхийг тодорхойлох боломжтой ч зарим нэг асуудал тулгарч байна. Тухайлбал:

1. **Хуулиар хориглоогүй байх** гэдэг шинжийг хүрээнд авч үзье. Шинэ төрлийн хөрөнгүүдийг тэр бүр хориглож, зөвшөөрөх эсэхийг хуульчлаад байх боломж хязгаарлагдмал. Эд баялаг, өмч хөрөнгөтэй холбоотой харилцаа нь хувийн эрх зүйд хамаарахын хувьд хориглосноос бусдыг зөвшөөрөх зарчмын ойлголтоор зохицуулах боломжтой. Өөрөөр хэлбэл эдийн бус баялаг цахим хөрөнгө гэж нарийн тодорхойлох боломжгүй гэж авч үзвэл заавал тодорхойлох гэхээсээ илүүтэйгээр ийм шинжийг хангаагүй тохиолдолд эдийн бус баялаг гэж үзэхгүй гэсэн хориглосон зохицуулалт оруулах байдлаар хүрээ хязгаар тогтоох боломжтой.
2. **Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүй байх** гэсэн шинжийн хүрээнд авч үзье. Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ гэж юуг ойлгох вэ? Энэ нь нэгдүгээрт тухайн зүйлийг бүх нийтээр хүлээн зөвшөөрөх тухай, хоёрдугаарт тухайн харилцаанаас үүсэх үр дагавар нь шударга ёсны зарчимд нийцэж, бусдад шаардах эрх үүсэхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй байх тухай ойлголт юм. Хэрэглээнд нэвтэрсэн цахим хөрөнгийн төрлүүдийг энэ шинжид хамааруулан авч үзвэл уг шинж хангагдах эсэх тун эргэлзээтэй..

Эдийн бус баялгийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтын хүрээнд дижитал хэлбэртэй хөрөнгүүдийг үүнд хамааруулан авч үзэхийн тулд хуульд шууд хамааруулан тодорхойлоход хэтэрхий ерөнхий байгаа бөгөөд нарийвчлан зохицуулах хэрэгцээ шаардлага байгаа юм биш биз гэсэн байдал шууд анзаарагдах боломжтой.

Мөн Иргэний хуулийн 84.5-д “Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөд хамаарна.” гэж хуульчилсан байна.

1. Эзэмшигч этгээддээ ашиг өгөх гэдэг шинжийг хэрхэн тодорхойлох вэ? Цахим хөрөнгүүд дийлэнхдээ ямар нэгэн тодорхой зорилготой хэрэглэгддэг хэрэглээний онцлогтой байдаг. Тухайлбал автобусны карт⁸ бол зөвхөн автобусанд зорчиход зориулагдсан бөгөөд мөнгөөр тухайн картыг цэнэглэх байдлаар хүн хүссэн газар

⁷ Финтек гэж /Fintech/ Financial technology буюу санхүүгийн технологи гэсэн холбоо үгний товчлол бөгөөд санхүүгийн үйлчилгээг технологийн дэвшилтэй уялдуулан санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хэрэглэгчдэд хүргэх үндсэн зорилготой салбар юм.

⁸ Карт /kart/ утгаа англи хэлний үг 3. Юм авах тусгай тусгай хуудас, тасалбар; картын системийг зогсоох; **Картын систем** (Хүнд хэцүү үед бараа таваар, идэш уушны зүйлийг олон нийтэд тэгш хуваарилахын тул тусгай тасалбараар олгох журам); Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 2021 он. 462 тал.

луугаа нийтийн тээврээр зорчих боломж бүрдэнэ. Үүнтэй холбоотой эзэмшигчид ашигтай байх гэдэгт анхаарах ёстой хоёр асуулт гарч ирнэ.

- Нийтийн тээврээр зорчих нь хувь хүний хувьд магадгүй эдийн засгийн хэмнэлттэй байгаа байдлыг ашигтай байна гэж үзэх үү?
 - Нөгөө талаас тухайн нийтийн тээврийн карт бол зөвхөн хэрэглээний объект учраас эдийн засгийн үр өгөөжгүй гэж үзэх үү?
2. Бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага байх гэсэн шинж бол тухайн цахим хөрөнгө эрх зүйн хамгаалалтад шууд байх ойлголт. Түрүүний нийтийн тээврийн картын жишээн дээр авч үзвэл тухайн картыг эзэмшигчийн зөвшөөрөлгүй зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй үйлдлээр хэн нэгэн этгээд уг картыг авсан тохиолдолд тухайн эзэмшигчид шаардах эрх үүсэх үү? Тухайн картад 300 нэгж түүнээс дээш хэмжээний төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэ цэнэ бүхий цэнэглэлт байвал Эрүүгийн эрх зүйгээр хамгаалагдах өмч хөрөнгө болох уу? гэдэг асуулт гарч ирж байна.

Үүнтэй ижил ойлголтууд бол цахим мөрийтэй тоглоомд хэрэглэгдэж буй тухайн мөнгөөр орлогдож буй зоос, мөн цахим бооцоот тоглоомд хэрэглэгдэж буй мөнгөөр орлогдож буй тухайн хөрөнгө, и-спортын тоглоомуудад ашиглагдаж буй янз бүрийн хөрөнгүүд гэх зэргийг эрх зүйгээр хамгаалагдаж байгаа юу гэдэг нь хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн хүрээнд дээрх байдлаар зохицуулагдахгүй байх боломжтой байдал харагдаж байгааг анхаарах хэрэгтэй.

Дүгнэлт

Цахим хөрөнгийн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хүмүүсийн нийгмийн шинэ харилцааны хэлбэрүүд илүү олноор урган гарч байна. Үүнтэй холбоотойгоор тухайн хэрэглээний объектыг эрх зүйн ямар нэгэн хамгаалалтад багтаах, хамгаалах нь төрийн үндсэн чиг үүрэг билээ. Иргэний эрх зүйн гол зарчим болох хориглосноос бусдыг зөвшөөрөх агуулгын хүрээнд шинэ төрлийн цахим хөрөнгүүдийн хэрэглээнд нэвтэрсэн байдал болон хуулиар хориглоогүй байгаа шинж зэрэг нь тухайн хөрөнгүүдийг ямар нэгэн байдлаар хүний өмч хөрөнгө гэж тооцож байгаагийн илрэл бөгөөд харин эрх зүйн зохицуулалтын хүрээнд ойлгомжгүй байдал үүсэж байх боломжтой байна.

Ойлгомжгүй байдал гэдэг бол шууд утгаараа эрсдэл юм. Өөрөөр хэлбэл дижитал хөрөнгө нь эдийн бус баялагт хамаарах эсэх, цаашлаад эрх зүйн хамгаалалтад байгаа юу? гэдэг асуулт, мөн шүүхийн практикт хэрэглээнд нэвтэрсэн хөрөнгүүдтэй холбоотой шаардах эрх үүсэх боломжтой эсэх, шүүх хуулийг хэрхэн хэрэглэж байгаа зэрэг анхаарах асуудал байна гэж үзэж байна.

1. Дижитал хөрөнгийн хуулиар хамгаалагдах шинжүүдийг тодорхойлох, нийтлэг байдлаар цахим хөрөнгө гэдэгт ийм ерөнхий шинж чанаруудыг агуулж буй хөрөнгийг хамааруулан авч үзнэ гэдэг хуульчилсан зохицуулалт нэн шаардлагатай байна.
2. Дээрх байдлаар тодорхойлж өгөх хэрэгцээ шаардлага нь нэг талаас хуулиар хязгаарлалт тогтоож өгснөөр цахим залилан зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг хязгаарлах, нөгөө талаас тухайн цахим хөрөнгө эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалах бүрэн боломжтой болох юм.